



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Отгонтэнгэр нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/02/СТА-ТӨХК**

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraad@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn</p> <p>Гэрээт аудитор:Ц.Алтантуул Утас: 91195554 Цахим хаяг : tuul9565@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /сая төгрөгөөр/.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	Error! Bookmark not defined.
3.8 Аудитын гол асуудал	9
Асуудал тодорхойлогдоогүй.....	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
4. Аудитын илрүүлэлт	10
4.1 Залруулсан алдаа байгүй.	10
4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.	10
4.3 Албан шаардлага хүргүүлээгүй.....	10
4.4 Зөвлөмж өгөгдөөгүй.....	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ОТГОНТЭНГЭР НИСЭХ БУУДЛЫН
ДАРГА Д.АЛТАН-УУЛ-Д

2022.06.25 № 1302/151

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Отгонтэнгэр нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Отгонтэнгэр нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	30,386,418.99	40,974,141.79
1.1.2	Дансны авлага	12,400,635.43	4,076,071.94
1.1.4	Бусад авлага	909,512.15	12,924,986.91
1.1.6	Бараа материал	115,430,956.01	91,755,550.79
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0	8,573,826.42
	Эргэлтийн хөрөнгийн дүн	159,127,522.58	158,304,577.85
1.2.1	Үндсэн хөрөнгө	13,321,814,083.04	13,122,719,724.05
1.2.2	Биет бус хөрөнгө	3,449,176,059.06	3,448,769,000.71
1.2.3	Дуусаагүй барилга	143,661,398.87	143,661,398.87
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	53,363,876.39	69,552,328.40
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,968,015,417.37	16,784,702,452.03
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	17,127,142,939.95	16,943,007,029.88
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	200,000.00	10,000,000.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	200,000.00	10,000,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	200,000.00	10,000,000.00
2.3	Эздийн өмч	3,953,845,084.77	3,953,845,084.77
2.3.1	Өмч: - төрийн	3,445,714,000.00	3,445,714,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	508,131,084.77	508,131,084.77
2.3.9	Хуримтлагдсан ашиг	13,173,097,855.18	12,979,161,945.11
	Эздийн өмчийн дүн	17,126,942,939.94	16,933,007,029.88
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	17,127,142,939.95	16,943,007,029.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.1.1	Борлуулалтын орлого	29,945,749.53	9,098,705.74
	Буулт хөөрөлтийн орлого	7,456,100.00	2,146,680.00
	Буудлын хураамж	5,527,200.00	1,227,600.00
	Бүртгэлийн цэгийн орлого	0	65,000.00
	Үнэмлэх борлуулсны орлого	503,636.36	30,000.00
	Газрын техник үйлчилгээний орлого	14,391,000.00	4,633,000.00
	Шатахуун тээвэрлэлтийн орлого	1,836,358.62	637,516.65
	Үйл ажиллагааны бусад орлого	186,000.00	358,909.09
	Боруулалтын орлогын дүн	29,945,749.53	9,098,705.74
1.2	Борлуулалтын өртөг	1,514,589,432.41	1,501,934,401.51
	Бичиг хэрэг	1,741,831.82	869,913.49
	Албан конторын зардал	1,185,969.74	674,545.46
	Шатахуун	38,630,948.20	31,583,617.99
	Үндсэн цалин	365,911,514.05	350,895,168.42
	Илүү цаг	36,982,948.58	6,187,606.67
	Амралтын мөнгө	66,485,655.04	63,817,383.44
	Цалингийн бусад нэмэгдэл	192,699,734.97	177,978,426.25
	Үндсэн ба нэмэгдэл цалингийн нийт дүн	662,079,852.64	598,878,584.78
	Хоолны үнийн хөнгөлөлт	105,600,000.00	100,035,000.00
	Нийгмийн даатгалын зардал (Үйлдвэрлэл)	103,802,639.87	98,553,605.12
	Сэлбэг засвар-Барилга	18,546,078.96	17,592,876.69
	Сэлбэг засвар-Автомашин	4,824,109.00	5,846,941.41
	Сэлбэг засвар-Аэродром	11,346,190.95	31,019,012.12
	Сэлбэг засвар -ТТ	28,718,675.30	13,557,164.49
	Сэлбэг засвар	63,435,054.21	68,015,994.71
	Цахилгаан	12,695,060.31	14,604,930.33
	Дулаан	22,108,865.17	19,567,233.53

	Усны зардал	1,321,000.00	1,800,000.00
	Холбооны зардал	11,541,263.83	11,357,166.95
	Ашиглалтын зардлын дүн	47,666,189.31	47,329,330.81
	Үндсэн хөрөнгийн элэгдэл	396,314,517.65	466,434,894.84
	Биет бус хөрөнгийн хорогдуулга	408,173.57	407,058.35
	Элэгдлийн зардлын дүн	396,722,691.22	466,841,953.19
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	16,989,459.78	16,919,009.75
	Газрын татвар	14,098,102.00	13,703,112.00
	Тээврийн хэрэгслийн татвар	369,992.00	361,518.00
	Хөрөнгийн даатгал	12,057,514.19	8,906,867.21
	Татвар, даатгалын зардлын дүн	43,515,067.97	39,890,506.96
	Хөдөлмөр хамгаалал	15,818,864.84	8,854,586.57
	Дотоод сургалтын зардал	92,000.00	1,902,348.58
	Сургалтын зардлын дүн	92,000.00	1,902,348.58
	Дотоод томилолт	16,222,543.75	19,900,600.95
	Албан томилолтын зардлын дүн	16,222,543.75	19,900,600.95
	Харуул хамгаалалт	2,267,577.61	1,376,855.14
	Цэвэрлэгээний зардал	3,396,810.36	3,621,453.60
	Лабораторын зардал	0	438,181.83
	Гал команд	3,359,505.07	8,574,770.41
	Тээврийн зардал	3,701,107.30	2,140,169.00
	Аудит баталгаажуулалтын зардал	1,268,510.32	1,476,000.00
	Үйлдвэрлэлийн бусад зардал	879,622.95	976,382.92
1.3	Нийт ашиг (алдагдал)	-1,484,643,682.88	-1,492,835,695.77
1.4	Үйл ажиллагаа (Борлуулалт, ерөнхий удирдлага)-ны зардал	828,000.00	864,000.00
	Аудит баталгаажуулалтын зардал	828,000.00	864,000.00
1.5	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	-1,485,471,682.88	-1,493,699,695.77
2	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	12,843,442,471.93	1,299,763,785.70
2.6.1	Бусад үйл ажиллагааны бус орлого	12,896,366,354.69	1,370,032,182.49
	Хүүгийн орлого	885,726.48	71,034.31
	Бусад үйл ажиллагааны бус орлого	9,960,000.00	12,123,884.62
	Санхүүжилт орлого	1,376,505,814.71	1,200,827,319.77
	Систем хоорондын тооцоогоорх орлого	885,633,713.43	156,776,590.29
	ҮХ-н дотоод хөдлөлийн борлуултын олз	10,623,381,100.07	233,353.50
2.6.2	Бусад үйл ажиллагааны бус зардал	52,923,882.76	70,268,396.79
	Шагнал	700,000.00	100,000.00
	Тэтгэмж	4,950,000.00	4,900,000.00
	Түлшний хөнгөлөлт	2,000,000.00	2,600,000.00
	Банкны үйлчилгээний зардал	70,840.00	57,660.00
	Эмнэлэг үйлчилгээний зардал	1,680,000.00	1,440,000.00
	Үйл ажиллагааны бус бусад зардал	1,282,312.66	16,440.77
	Систем хоорондын тооцоогоорх зардал	33,665,730.10	59,075,808.71
	ҮХ данснаас хассаны гарз	0	2,078,487.31
	ҮХ данснаас хассаны олз, гарзын зөрүү	0	-2,078,487.31
2.3	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн	12,843,442,471.93	1,299,763,785.70
3	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	11,357,970,789.04	-193,935,910.06
4	Татварын дараах ашиг (алдагдал)	11,357,970,789.04	-193,935,910.06
5	Ердийн ажиллагааны ашиг (алдагдал)	11,357,970,789.04	-193,935,910.06
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	11,357,970,789.04	-193,935,910.06

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
-----	----------	-----	-------------------------------------	--------------------	----------

1	2020 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	3,445,714,000.00	508,131,084.77	13,173,097,855.18	17,126,942,939.95
2	Залруулсан үлдэгдэл	3,445,714,000.00	508,131,084.77	13,173,097,855.18	17,126,942,939.95
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	-193,935,910.06	-193,935,910.06
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0	0
6	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0
8	2021 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	3,445,714,000.00	508,131,084.77	12,979,161,945.11	16,933,007,029.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,162,427,638.46	1,202,172,678.74
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	16,388,499.58	4,847,663.63
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,120,872,556.00	1,173,323,091.65
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	24,632,697.48	24,001,923.46
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,021,649,567.22	1,056,379,752.60
1.2.1	Ажиллагчдад төлсөн	582,634,297.91	583,052,433.33
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	175,036,275.05	182,378,914.30
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	44,226,568.00	41,555,646.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	24,614,823.96	29,377,063.10
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	71,314,736.14	80,206,083.44
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	88,837,953.49	86,605,164.32
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	12,057,514.19	4,040,950.00
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	22,927,398.48	49,163,498.11
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	140,778,071.24	145,792,926.14
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	885,726.48	71,034.31
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	885,726.48	71,034.31
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	114,010,556.00	135,276,237.65
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	114,010,556.00	135,276,237.65
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-113,124,829.52	-135,205,203.34
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	27,653,241.72	10,587,722.80
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	27,653,241.72	10,587,722.80
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,733,177.27	30,386,418.99
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,386,418.99	40,974,141.79

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Отгонтэнгэр нисэх буудал-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Отгонтэнгэр нисэх буудал 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 11-ний өдрийн 3/04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Отгонтэнгэр нисэх буудал нь Нисэхийн аюулгүй байдлыг ханган ажиллах, олон улсын иргэний нисэхийн байгууллага, стандарт, шаардлагад нийцсэн нисэх буудал болох зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос туслалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Отгонтэнгэр нисэх буудал -ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1,056.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 15.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	159.13	158.30	0.82
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,968.02	16,784.70	183.31
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	17,127.14	16,943.01	184.14
4	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0.20	10.00	(9.80)
5	Эздийн өмчийн дүн	17,126.94	16,933.01	193.94
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	17,127.14	16,943.01	184.14

Эргэлтийн хөрөнгийн дүн 0.82 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын бууралттай холбоотой байна.

Эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдэл 183.31 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгө шилжүүлсэн болон данснаас хассан мөн тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 9.8 мянган төгрөгөөр өссөн нь харицлагч байгууллагатай холбоотой үүссэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 193.94 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн ашиг буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөрийн орлогоос 38,500.0 мянган төгрөг, улсын төсвөөс 1,227,153.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,265,653.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 30,386.4 мянган төгрөг байсан бөгөөд гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагааны татаас санхүүжилтийн орлого 1,030,920.0 мянган төгрөгийн, өөрийн үйл ажиллагааны орлого 16,816.8 мянган төгрөгийн нийт 1,047,736.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,047,149.1 мянган төгрөгийг, 30,974.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ИНЕГ-ын даргын тушаалаар худалдан авах ажиллагааны эрх шилжилт хийгдэн аймгийн худалдан авах ажиллагааны газраар нээлттэй тендер зарлагдаж Хэрмээдэй ХХК Аэровокзалын барилгын гадна фасадны их засварын ажлыг хийж гүйцэтгэхээр шалгарсан. Уг их засварт 142,403.1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлээрх зардалд 132,403.1 мянган төгрөгийг зарцуулж, хийгдээгүй ажлын баталгаа болгон 10,000.0 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр үлдээсэн.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Асуудал тодорхойлогдоогүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангаар зөвлөмж өгөгдөөгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарах асуудал тодорхойлоогүй.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Залруулсан алдаа байгүй.

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй.

4.4 Зөвлөмж өгөгдөөгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1.											
	Дүн										